

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим

2.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүй, стандартын хэрэгжилтийг хангуулах хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсч байгаа хүчин зүйл, шалтгааныг тогтоон, үйлдвэрлэлийн осол, ослын тохиолдлыг бууруулах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэнэ.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

2.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүүргийн дэд хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн түвшинд, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд шинэлэг, үр нөлөөтэй арга хэлбэрээр тогтмол зохион байгуулж, хууль тогтоомж, стандартыг мөрдүүлж хэвшүүлэх.

2.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад ажил олгогчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтан аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв хандлагыг төлөвшүүлнэ.

2.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналтын үр нөлөөтэй арга хэлбэрийг төлөвшүүлнэ.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон түүнтэй уялдах бусад эрх зүйн баримт бичигт нэгдмэл байх.
- ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх.
- ✓ Судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх.
- ✓ Салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, нийгмийн түншлэлийг эрхэмлэх.
- ✓ Эрсдэлтэй бүлэгт түлхүү анхаарах.

Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

3.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүүргийн дэд хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн түвшинд, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд шинэлэг, үр нөлөөтэй арга хэлбэрээр тогтмол зохион байгуулж, хууль тогтоомж, стандартыг мөрдүүлж хэвшүүлэх 1 дүгээр зорилтын хүрээнд:

3.1.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээг /хороодын иргэдийн нийтийн хурлын дарга, гишүүд болон Засаг дарга нар/ зохион байгуулж хэвшүүлэх.

3.1.3. Иргэдэд эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулах боломж, нөхцөлөөр хангах.

Хүрэх үр дүн: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эрүүл, аюулгүй орчин нөхцөлд ажиллаж амьдрах ойлголт, хандлага иргэдэд төлөвшсөн байна.